

**Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хяналтад авсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт**  
 (Хяналт шалгалтын газар- 2025 оны I сар)

2025 оны 02 дугаар сарын 05

Улаанбаатар хот

Шийд-вэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
1	2	3	4	5	6	7	8
<b>Засгийн газрын тогтоол</b>							
17	23	Орон сууцны хороолол, цогцолбор барилгад хүүхдийн цэцэрлэг байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-09  Дугаар 2022_402	1.2. байнгын ашиглалтад хүлээн авсан орон сууцны хороолол, цогцолборын хэмжээнд барилгын норм, дүрмийн шаардлага хангасан цэцэрлэг төлөвлөгдөн баригдсан эсэхэд үзлэг хийж, дунг танилцуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазарт;	- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Салбарын хяналт газрын ерөнхий байцаагчийн 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн “Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 02-00/05 дугаартай удирдамж, Нийслэлийн Хяналт шалгалтын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн “Улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийгдэх барила, байгууламжид урьдчилсан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 02-13-01/023/04 дугаартай удирдамж тус тус батлагдсан бөгөөд барила угсралтын ажил эхлэх үед буюу 2025 оны 03 дугаар сарын 15-аас эхлэн хяналт шалгалт хийхээр төлөвлөж байна. - Барилга байгууламжийг ашиглалтад оруулах чиг үүргийн хүрээнд Баянзүрх дүүргийн 38 дугаар хороо, Сонгинохайрхан дүүргийн 18 дугаар хороонд батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу цэцэрлэг бүхий орон сууцны зориулалттай 2 барилгыг ашиглалтад хүлээн авсан.	30%		
				1.3. цэцэрлэгийн барилга төлөвлөөгүй орон сууцны хороолол, цогцолбор барилгын зураг төслийг баталж магадлан хийсэн, барилгын ажлын зөвшөөрөл олгосон, хүлээн авч ашиглалтад оруулсан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулах талаар зохих арга хэмжээ	Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 212 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ashiглалтад оруулах дүрэм”-ийг дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. Батлагдсан зургийн дагуу цэцэрлэгийн барилга төлөвлөөгүй орон сууцны хороолол, цогцолборын барилга болон хууль, норм		

1	2	3	4	5	6	7	8
			авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	стандарт зөрчсөн барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулаагүй болно. 2025 онд дээрх чиглэлээр төлөвлөгөө боловсруулж, холбогдох арга хэмжээний саналыг хүргүүлэхээр төлөвлөж байна.			
<b>ЗГ-ЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ</b>							
107	183	2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр 47 дугаар тэмдэглэл 2022-09-28 Дугаар 2022_47	IX.1.6. “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм”-д заасан хүн ам, барилгажилтын тооцоот нягтралын хязгаарыг давсан байршилд зөвшөөрөл олгосон барилгын ажлын хуульд заасан норм, шаардлага, стандартыг хангуулах, хэрэгжилтийн явцыг 2022 оны 10 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Барилга хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт;	2025 оны 01 дүгээр сард иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын дагуу барилгажилтын нягтралын хязгаарыг давсан дараах 2 байршилд хяналт шалгалт хийж, холбогдох баримт бичгийг шалгаж, зөвшөөрлийг цуцуулах талаар улсын байцаачийн дүгнэлт гаргахаар ажиллаж байна. Үүнд: - Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо иргэн А.Амарзоригтын үйлчилгээтэй орон сууцны барилга, - Баянзүрх дүүргийн 13 дугаар хороо дахин төлөвлөлтийн ГХ-БЗД07 багцын 3 хэсэгчилсэн талбайд гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл.	30%		
133	242	2023 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр 36 дугаар тэмдэглэл 2023-09-06 Дугаар 2023_36	XIII.6.“Бүянт-Ухаа спортын ордон” ТӨҮГ-ын барилга байгууламжийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Бүянт-Ухаа спортын ордон” ТӨҮГ-ын барилга байгууламжийн талаар нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын паспортжуулах шийдвэрт үндэслэн холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ашиглалтад оруулах арга хэмжээ авахыг Нийслэлийн Засаг	“Бүянт-Ухаа спортын ордон” ТӨҮГ-ын барилга байгууламж нь Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 211 дүгээр тушаалаар баталсан “Барилга, байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах зориулалт, хүчин чадлыг тогтоох журам”-д зааснаар онцгой төвөгшилтэй барилга байгууламжид хамаарна. Иймд Барилгын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 33 дугаар зүйлийн 33.1.23-д зааснаар онцгой төвөгшилтэй барилгыг ашиглалтад оруулах асуудлыг Барилга, хот байгуулалтын яам хариуцдаг. Дээрх асуудлаар Хяналт шалгалтын газраас Биеийн тамир, спортын сайд Б.Бат-Эрдэнэ, Барилга, хот байгуулалтын яамны	100%		Хасуулах саналтай

1	2	3	4	5	6	7	8
			дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумьяабазарт, тус барилгыг ашиглалтад оруулсан тухай дүгнэлтэд үндэслэн ашиглалтын гэрчилгээ олгохыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэнд тус тус даалгав.	төлөөллүүдтэй уулзалт хийж, ашиглалтад оруулах ажлыг тус яам хариуцахаар шийдвэрлэсэн болно.			
147	275	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэл	15.1. 2021 оны 11 дүгээр сараас 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор зөвшөөрөлгүй баригдсан барилга байгууламжийн ўе шатны зөвшөөрлийг мөрдөгдөж байгаа норм, дүрэмд заасан шаардлагыг хангасан эсэхийг тогтоосон мэргэжлийн байгууллага, ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн барилгын ажлын зөвшөөрөл болон ўе шатны баримт бичгийг нэг удаа нөхөн олгох боломжийг хууль тогтоомжийн хүрээнд судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт тус тус даалгав	Барилга, хот байгуулалтын Сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024 оны 35/A/163 дугаартай хамтарсан тушаал, захирамжаар энэхүү асуудлыг судлах ажлын хэсэг байгуулагдсан. Нийслэлийн хэмжээнд зөвшөөрөлгүй барьсан 108 иргэн, аж ахуйн нэгжийн 210 блок барилга байгууламжийн судалгааг нэгтгэн ажлын хэсэгт хүргүүлсэн. Одоогоор Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас тодорхой шийдвэр ирээгүй байна.	70%		
160	313	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 19 дүгээр тэмдэглэл 2024-05-15 Дугаар 2024_19	3.Хот байгуулалтын норм, стандартын дагуу цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн барилга барих зориулалтаар газар чөлөөлөх, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль баригч орон сууцны хоткон, хорооллыг ашиглалтад хүлээн авахгүй байх, ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд тухайн орон нутгийн боловсрол, шинжлэх ухааны газраас төлөөлөл оруулж, хяналтыг	- Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын ўйл ажиллагааг зохион байгуулан ажиллахдаа Хот байгуулалт, хотын стандартын газраас баталсан төлөвлөлт, барилгын ажлын зөвшөөрлийн дагуу байнгын ашиглалтад хүлээн авдаг. - Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын жишиг бүрэлдэхүүнийг баталсан бөгөөд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын	30%		

1	2	3	4	5	6	7	8
			арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав	яамнаас дээрх тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулагдаж байна. - Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдсан ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд нийслэлийн Боловсролын газрын төлөөлөл тогтмол оролцож байна. 2025 оны нэгдүгээр сарын байдлаар нийт 4 (цэцэрлэг-2, ерөнхий боловсролын сургууль- 2) барилга байгууламжийг ашиглалтад оруулсан байна.			

ХЯНАСАН:

ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ TYP ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН АХЛАХ  
МЭРГЭЖИЛТЭН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:

ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ТАЙЛАН ХАРИУЦСАН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



М.ШИЖИРБАЯР

С.БОЛДОО

М.ГАЧМАА